



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2017 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/134


Улаанбаатар хот

**Төрийн албан хаагчийн сургалтын
хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.1 дэх заалтыг, яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.2.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
- 2.Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /У.Отгонбаяр/-т даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

Барилга, хот байгуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны
АТ 134 дугаар сарын -ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Хөтөлбөр боловсруулах үндэслэл:

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлд төрийн байгууллага нь “Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан нь энэхүү хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн үндэс нь болно.

Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага:

Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл нь төрийн захиргааны бүх шатны байгууллага зорилт, чиг үүргээ мэдлэг чадвартай хүний нөөцийн хүчээр хэрэгжүүлэх, иргэдэд чанартай төрийн үйлчилгээ үзүүлэх шинэ шаардлага, хариуцлагын шинэ тогтолцоог бий болгохыг шаардаж байна.

Иймд төрийн байгууллага боловсон хүчнээ чадваржуулах, шинэ мэдлэг, боловсрол олгох, мэргэшүүлэх ажлыг шинэ шатанд гаргах, нөөц бүрдүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Хоёр. Хөтөлбөрийн ерөнхий зорилго

Хөтөлбөрийн зорилго нь төрийн албан хаагчдын боловсролын түвшин, мэргэшсэн байдал болон сайдын эрхлэх асуудал, ирээдүйн хэрэгцээ, түүнийг хангахад чиглэсэн сургалтын үр дүн, нөөцөд үндэслэн боловсруулсан болно.

Хөтөлбөрийг төрийн албан хаагчдыг сургахтай холбогдуулан шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулах, дэмжихэд ашиглана.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх зарчим

Төрийн албан хаагчийг ажлын байранд нь сургах, өөр байгууллага, хамт олноос суралцах буюу богино хугацааны зорилтот сургалтаар давтан сургах, боловсролын мэргэжлийн байгууллагад суралцуулах, тодорхой сэдэв эсвэл мэргэжлээрээ дагнан суралцах гэсэн 4 зарчимд тулгуурлан зохион байгуулна.

Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагаагаа сайжруулахын тулд албан хаагч нэг бүрийг ажлын байранд нь сургана

Шинэ албан тушаалд томилогдсон, албан тушаалын ангилал, зэрэглэл ахисан, өөр ажилд шилжсэн үед тухайн албан тушаалын онцлог, тавигдах шаардлагад нийцүүлэн сургалтад хамруулж байх. Энэ чиглэлээр сургалт явуулах байнгын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Уг хөтөлбөр, төлөвлөгөөндөө мэдлэг, туршлагатай ажилтныг дагалдуулж сургах, өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөртэй ажиллуулах, ажил, албан тушаал сэлгэн ажиллуулах талаар тусгасан байна.

Байгууллага бүр оны сүүлчийн улиралд дараа жилийнхээ сургалтын хэрэгцээгээ тодорхойлох, төлөвлөх ажлыг зохион байгуулна. Үүний тулд хамт олны

Эрдэм шинжилгээний зориулалттай туршилтын болон үндсэн лаборатори, ажлын байр, тоног төхөөрөмж зэргийг бий болгох, шинээр байгуулах асуудлыг шат дараалан шийдвэрлэж ажиллана.

Дөрөв. Сургалтад оролцуулах ажилтанд тавигдах шаардлага

Ерөнхий шаардлага:

- Үр дүнгийн гэрээ болон цаг үеийн ажлын биелэлт 80% -нас дээш, ажлын үр дүн гарсан байна.
- Яамны хөдөлмөрийн дотоод журамд заасан болзол, шаардлага хангагдсан байна.

Гадаадад сургалтад хамрагдахад тавигдах нэмэлт шаардлага:

- Тухайн сургалтын шаардлагын дагуу гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх;
- Ажлын байрны зайлшгүй шаардлага тодорхойлогдсон байх;

Байгууллагын захиалгаар гадаадын өндөр хөгжилтэй орны магистрантурын сургалтад хамрагдахад тавигдах нэмэлт шаардлага:

- Тухайн чиглэлээр бакалавраас доошгүй зэрэгтэй /сургалтын голч дун нь 3.0 оос доошгүй/ байх;
- Гадаадын өндөр хөгжилтэй орны тухайн сургуулийн тухайн мэргэжлийн чиглэлээр шаардаж буй TOEFL -ийн онооны болзлыг хангасан байх;
- Сургалтын үед хийх судалгаа, сургалтын дараа хийх ажлын төсөөлөл, зорилго, одоогийн байдалд хийсэн дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдсэн байх;
- Захиалсан мэргэжлийн чиглэлийн дагуу олон улсын нэр хүндтэй их сургуулийн үндсэн сургалтад элссэн буюу элсэн суралцах болзол шаардлагыг хангасан байх;
- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх;
- Тухайн албан хаагчийн бодитой хийсэн ажлын бүтээл, жагсаалт, идэвхи, санаачлага тодорхойлогдсон байх;

JDS, JICA, KOICA,-ийн чиглэлээр суралцахад тавигдах нэмэлт шаардлага

- Ажлын байрны чиглэлээр тодорхой томоохон үр дүнтэй ажилд оролцсон байдал.
- гарсан үр дүн тодорхойлогдсон байх;
- Ажлын байрны зайлшгүй шаардлага тодорхойлогдсон байх;
- Гадаад хэлний мэдлэгт тавигдах шаардлага хангасан байх;
- Албан хаагчийн идэвхи, санаачлага тодорхойлогдсон байх;
- Ажилласан жил хангагдсан байх;
- Сургалтад хамрагдсан давтамжийг харгалзана.

Богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахад тавигдах нэмэлт шаардлага:

- Ажлын байрны чиглэл, ажилласан жил, ажлын үр дүн шаардлага хангасан байх;
- Богино хугацааны сургалтад хамрагдсан давтамжийг харгалзана.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

Хөтөлбөрийг 2020 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- Байгууллагын төсөв
- Олон улсын хамтын ажиллагааны сайн санааны санхүүжилт
- Хоёр болон олон талын хамтын ажиллагааны хурээнд харилцан тохиролцооны

дунд ярилцлага хийх, судалгаа авах, байгууллага, нэгжийн зорилт, ажлын байрны тодорхойлолт, албан тушаалын шинжилгээ, ажлын үзүүлэлт зэргийг харгалзан үзнэ. Мөн мэргэжлийн байгууллага, сургууль, багш мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

Шинэ залуу ажилтнуудыг мэдлэг, туршлагатай ажилтныг дагалдуулж сургах, өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөртэй ажиллуулах, туршилтын хугацаанд хийх ажил, үүргийг нь тодорхой болгон үр дүнгийн гэрээ байгуулж ажиллана.

Ажилтны онцгой ур чадвар, ажлын туршлагад тулгуурлан тодорхой хугацаа, сэдвээр шинэ зүйлийг боловсруулахаар томилон ажиллуулах, туршилт, судалгаа хийлгэнэ.

Ажилтан бүр чиг үүрэг, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ өөрийн хүч, авьяас, мэдлэг чадвараа дайчлан ажиллахын зэрэгцээ шинэ санаа, шинэ арга барилд суралцах, мэдээлэл хайж олж авах, туршилт хийх, шийдэлд хүрэх ба шинээр олсон зүйлээ бусдад мэдээлэх, хуваалцана.

Мэдлэг, мэдээллээ хуваалцахыг ажлын хэвшмэл хэсэг болгож, аливаа асуудлыг багаар ажиллах зарчмаар оновчтой шийдэлд хүрэх арга барилд сургах, үүний тулд тухайн хамт олны дунд багаар шийдвэрлэх асуудлыг урьдчилан төлөвлөсөн байна.

Албан тушаалтан бүр өөрийн хариуцсан ажил, үүргийнхээ чиглэлээр сургалтын материал, гарын авлага, ном товхимол гарган бусдын хүртээл болгоно.

Харъяа агентлаг болон мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтарсан буюу бие даасан сургалт, семинарыг зохион байгуулахаар жилийн төлөвлөгөөндөө тусгаж ажиллана.

Гадаадад явж суралцсан буюу туршлага судлах хөтөлбөрт хамрагдсан албан хаагч бүр үзсэн, сурсан бүхнээ хамт олон, бусдад мэдээлэх, уулзалт ярилцлага хийх, сургалт зохион байгуулж хэвших, гарын авлага, заавар зөвлөмж гаргаж ажиллана.

Төрийн албан хаагчдыг гадаад, дотоодын сургуулиудад сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, удирдах ажилтны нөөц бүрдүүлэх, ирээдүйн шинэ залуу ажилтныг сургах, бэлтгэх ажлыг зохион байгуулна.

Ажилтнуудыг гадаад, дотоодод сургах, мэргэшүүлэх хэрэгцээ, шаардлагыг урьдчилан судлах, төлөвлөх, сургалтад хамрагдсаны дараа хамтран ажиллах зэрэг үүргийг байгууллагын Төрийн захиргааны удирдлагын газар хариуцаж ажиллана.

Хүний нөөцийн төлөвлөгөө, судалгаа, албан тушаалтны гүйцэтгэлийн чадвар зэргийг үндэслэн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг мэргэжлийнх нь дагуу буюу ерөнхий мэдлэгийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад дэс дараатайгаар хамруулна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилт, хүний нөөцийн хөгжлийн бодлогын дагуу гадаадын улс орнуудад сургаж бэлтгэх талаар тусгай төсөл хэрэгжүүлнэ.

Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний дагуу төрийн болон нийгмийн удирдлагын мэргэшүүлэх, менежер, магистр бэлтгэх сургалтад хамруулж ажиллана.

Салбарын хэмжээнд нэн чухал шаардлагатай мэргэжлийн судалгаа гаргаж тэдгээр мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах ажлыг дэмжиж ажиллана.

Төрийн албан хаагчдыг тодорхой сэдвээр мэргэшэх, эрдмийн цол зэрэг хамгаалах, бие даан бүтээл туурьвах зэрэг үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

Эрдмийн ажил, сорил туршилт хийх, судалгаа шинжилгээ явуулах талаар эрдэмтдийн мэргэжлийн зөвлөл, багш, удирддагчдыг урьж сургалт семинар хийлгэх, ярилцлага, зөвлөгөө өгүүлэх зэргээр дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

ундээн дээр гаргаж байгаа буцалтгүй тусламж, техникийн туслалцаа

○ Зарим онцгой тохиолдолд төрийн албан хаагчдын өөрсдийнх нь хандив байж болно.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Төрийн захиргааны удирдлагын газар хариуцаж ажиллана.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага нь албан хаагч нэг бүрийг ажлын байранд нь сургах талаар өөрийн байгууллагын дотоод журмандаа тусгаж хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар гүйцэтгэнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хамаарах хууль, тогтоомж, дүрэм, журам өөрчлөгдсөн тохиолдол бүрт Төрийн захиргааны удирдлагын газар нэмэлт өөрчлөлт, тайлбар, тодруулга хийх бөгөөд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хариуцаж ажиллана.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр салбарын хүний нөөцийн чадамж боловсрол, ажлын дадлага, туршлагатай мэргэшсэн ажилтнаар бүрдэж, тэдгээрийг албан тушаалын чиг үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөл, нийгмийн баталгааг хангах, үр дүнтэй ажиллах орчин нөхцлийг бий болгож, мэргэжлийн үр чадварыг нь дээшлүүлэн, амьдралын баталгаат нөхцлийг сайжруулснаар төрийн уйл ажиллагааны тасралтгүй чанар, байнгын идэвхитэй уйл ажиллагаа хангагдана.

○ Нийт албан хаагчдын 50 хувийг магистрын зэрэгтэй, 50 хувийг албан хэрэгцээндээ англи хэлийг ашиглах чадварыг эзэмшүүлнэ.

○ Шинээр ажилд орсон албан хаагчдыг төсөл, хөтөлбөр, бодлогын баримт бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөх чадвар эзэмшүүлнэ.

○ Шинэ мэдлэг чадвар, туршлага бий болгосноор сайн үйл ажиллагаатай, чадварлаг төрийн албыг төлөвшүүлнэ. Байгууллагын дотоод нөөцийг ашиглаж, ажлын байран дээрх сургалтыг хөгжүүлнэ.

○ Хувь хүний мэдлэг чадвар, туршлагыг байгууллагын мэдлэг чадвар, туршлага болгон хөгжүүлж, багаар ажиллах системийг хэрэгжүүлснээр төрийн зүгээс иргэдэд узуулэх уйлчилгээ улам чанаржиж, байгууллагын зорилт, чиг уурэг бүрэн хэрэгжих үндэслэл болно.

○ Хөтөлбөрийн хэрэгжилтэд яамны удирдлага, албан хаагчид хяналт тавина. Хэрэгжилтийн талаар удирдлага, албан хаагчид тодорхой санал, хусэлт гаргана.